“ЭРДЭНЭТ ҮЙЛДВЭР” ТӨҮГ

ЛААЗАЛСАН МАХ
Дугаар: ЭҮТӨҮГ/202101437

Тендерийн нэр: ЛААЗАЛСАН МАХ

Тендер шалгаруулалтын код: ЭҮТӨҮГ/202101437

2021 он

Нэг. ТЕНДЕРИЙН УРИЛГА

Огноо: 2021 оны 03 дугаар сарын 03

Тендер шалгаруулалтын нэр: Лаазалсан мах нийлүүлэх
Тендер шалгаруулалтын дугаар: ЭҮТӨҮГ/202101437

"Эрдэнэт үйлдвэр" ТӨҮГ нь эрх бүхий тендерт оролцогчдоос Лаазалсан мах нийлүүлэх тухай цахим тендер ирүүлэхийг урьж байна.

Энэхүү барааны тендер шалгаруулалт нь цахим худалдан авах ажиллагааны системээр зарлагдаж байгаа цахим тендер тул www.tender.gov.mn хаягаар орж дэлгэрэнгүй мэдээлэл болон цахим тендерийн баримт бичгийг авна уу.

Тендер нь түүнийг нээсэн өдрөөс эхлэн 30 хоногийн дотор хүчинтэй байна.
Тендерийн төсөвт өртөг: **17,737,431** ***төгрөг***
Тендерийн баталгааг цахим баталгаа гаргах эрх бүхий арилжааны банкаар, мөн Монгол улсын засгийн газрын бонд эсхүл Монгол улсын засгийн газраас зөвшөөрсөн үнэт цаасны хэлбэрээр ирүүлж болно.

Тендерийг 2021 оны 03 дугаар сарын 22-ны өдрийн 08 цаг 30 минутаас өмнө системд ирүүлэх ба нээлтэд оролцох хүсэлтэй тендерт оролцогчдыг байлцуулан тендерийг 2021 оны 03 дугаар сарын 22-ны өдрийн 08 цаг 40 минутад нээнэ.

Сонирхсон этгээд тендерийн баримт бичиг болон бусад мэдээллийг доорх хаягаар авч болно. *www.tender.gov.mn*

Орхон аймаг, Баян-Өндөр сум, Найрамдал талбай, Эрдэнэт үйлдвэр ТӨҮГ-ын Ерөнхий захиргааны II байр, 1106 тоот өрөө,
Утас: 75773768

Хоёр. ТЕНДЕРТ ОРОЛЦОГЧДОД ӨГӨХ ЗААВАРЧИЛГАА

1. Эрх бүхий тендерт оролцогч ба эрх бүхий бараа	1.1.	Тендерт оролцогч нь “Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай” хуулийн 14-16 дугаар зүйл буюу Тендер шалгаруулалтын өгөгдлийн хүснэгт /цаашид “ТШӨХ” гэх/-д заасан холбогдох шаардлагыг хангасан байна.
2. Тендер ирүүлэх, тендерийн нээлт	2.1.	Захиалагч тендерүүдийг ТШӨХ-д заасан захиалагчийн хаягаар, ТШӨХ-д заасан огноо, цагаас өмнө хүлээн авна.
	2.2.	Тендерийг ТШӨХ-д заасан хугацаанд, ТШӨХ-д заасан газар нээлтийг хийнэ.
	2.3.	Тендерт оролцогч тендерийн материалд Хувь хүний нууцын тухай болон Байгууллагын нууцын тухай хуулиудаар ил болгохыг хориглосон мэдээллийг тусад нь хавтаслаж ирүүлнэ. Тус хавтасны эхэнд тэдгээр мэдээллийг нууцлах үндэслэлийг бичгээр тайлбарлаж, тендерт оролцогчийн итгэмжлэгдсэн этгээд гарын үсгээр баталгаажуулна. Эрх бүхий тендерт оролцогч болохыг нотлох ТШӨХ-д заасан баримт бичиг, тендерийн баримт бичигт заасан маягтуудыг нууцлахгүй ирүүлнэ.
3. Тендерийн иж бүрдэл	3.1.	Тендерт оролцогчийн бэлтгэж ирүүлэх тендер нь дараах зүйлээс бүрдэнэ. Үүнд: (а) Үнийн санал; (б) Үнийн болон нийлүүлэлтийн хуваарь; (в) Чадварын мэдээлэл /санхүүгийн тайлан, туршлагын мэдээлэл, гэрээ гүйцэтгэсэн ажлын гэрээний хуулбар/ болон бусад баримт бичиг; (г) Шаардлагатай тусгай зөвшөөрөл; (д) [Бэлтгэж ирүүлэх шаардлагатай бусад материалыг жагсаана.]
4. Тогтмол үнэ	4.1.	Тендерт оролцогчийн санал болгосон үнэ нь төгрөгөөр илэрхийлэгдсэн байх ба гэрээг хэрэгжүүлэх хугацаанд тогтмол байна. Үнийн тохируулгын нөхцөлтэйгээр ирсэн үнийн саналаас татгалзана.

5. Техникийн тодорхойлолт ба арилжааны нөхцөлүүд	5.1.	Нийлүүлэх бараа нь техникийн тодорхойлолтын шаардлагыг бүрэн хангасныг тендерт оролцогч батлах үүрэгтэй. Нийлүүлэх бараа нь техникийн тодорхойлолтын шаардлагаас зөрсөн тохиолдолд тухайн тендерээс татгалзана.
	5.2.	Тендерт оролцогч нь энэ баримт бичигт заасан арилжааны нөхцөлүүдийг бүрэн хангасныг албан бичгээр батлан тендерийн хамт ирүүлнэ.
6. Үнийн саналын хүчинтэй байх хугацаа	6.1.	Үнийн санал нь түүнийг ирүүлсэн өдрөөс хойш 30 хоногийн хугацаанд хүчинтэй байна.
7. Санал болгосон үнэ, түүнийг үнэлэх	7.1.	Тендерт оролцогч үнийн саналдаа холбогдох бүх даатгал, тээврийн зардал, татвар, хураамжийг оруулж үнийн хуваарийн дагуу ирүүлнэ.
	7.2.	Бараа нийлүүлэлтийн хуваарьт заасан бараа нь ***ТШӨХ-д*** заасан багцаас бүрдэх ба багцад орсон нэр төрөл бүрд заавал үнийн санал ирүүлнэ.
	7.3.	Захиалагч техникийн тодорхойлолт болон бусад нөхцөл шаардлагыг хангасан оролцогчдын үнийг харьцуулж хамгийн бага үнэ санал болгосон тендерт оролцогчид гэрээ байгуулах эрхийг олгоно.
8. Гэрээ байгуулах эрх олгох тухай мэдэгдэл	8.1.	Захиалагч нь шалгарсан тендерт оролцогчид гэрээ байгуулах эрх олгосныг түүний тендер хүчинтэй байх хугацаа дуусахаас өмнө албан бичгээр мэдэгдэнэ. Энэ мэдэгдэлд гэрээнд заасны дагуу хийгдэх ажилд төлөх мөнгөн дүн буюу гэрээний үнийг заана. Гэрээний үнэ нь залруулга болон үнийн хөнгөлөлтийг (түүний дотор нөхцөлтэй үнийн хөнгөлөлт) тооцсон тендерийн үнэ байна.

Гурав. ТЕНДЕР ШАЛГАРУУЛАЛТЫН ТЕХНИКИЙН ТОДОРХОЙЛОЛТ ӨГӨГДЛИЙН ХҮСНЭГТ

ТОӨЗ-ны холбогдох заалт	Шалгуур үзүүлэлт
ТОӨЗ 1.1	Монгол Улсын хуулийн дагуу татвар, хураамж, төлбөрөө тухайн тендер ирүүлсэн өдрийн байдлаар бүрэн төлсөн байна. Татвар төлсөн тухай баримт ирүүлэх шаардлагагүй. Төрийн худалдан авах ажиллагааны цахим системээр дамжуулан Татварын ерөнхий газрын татвар төлөгчдийн мэдээллийн сан /mta.gov.mn/-аас тендерт оролцогчдын татвар, хураамж, төлбөрөө тухайн тендер нээсэн өдрийн байдлаар бүрэн төлсөн эсэхийг шалгана.
ТОӨЗ 2.1	**Тендерийн нээлт хийх газар, хугацаа нь:** Үнийн саналыг ***2021 оны 03 дугаар сарын 22-ны өдрийн 08 цаг 30 минутаас*** өмнө цахим тендер шалгаруулалтын журмаар авна.
ТОӨЗ 2.2	Уг тендер нь цахим тендер шалгаруулалтын журмаар зохион байгуулагдаж байгаа тул тендерт оролцогч нь цахим худалдан авах ажиллагааны систем /www.tender.gov.mn./-д өөрийн аж ахуйн нэгжийн хувийн нууцлалын кодоор нэвтрэн орж тендерийн материалаа цахим хэлбэрээр ирүүлнэ. Үнийн саналыг цахим тендерын журмаар ***2021 оны 03 дугаар сарын 22-ны өдрийн 08 цаг 40 минутаас нээнэ.***
ТОӨЗ 3.1	Тендерт оролцогч нь дараах материалыг хавсралтаар ирүүлнэ. Үүнд: - Үнийн санал - Барааны жагсаалт ба бараа нийлүүлэлтийн хуваарь - Санхүүгийн тайлан. Нэг жил (2019 он). Санхүүгийн тайланг цахим системээр дамжуулан Монгол улсын сангийн яамны мэдээллийн сан /e-balance/-аас тендерт оролцогчдын борлуулалтын орлого, ашигтай ажилласан эсэх, түргэн хөрвөх чадвартай хөрөнгийн талаарх шаардлагатай мэдээллийг шалгана. - Татварын байгуулагаас тодорхойлолт хүсэхэд татгалзах зүйлгүй тухай тендерт оролцогчийн албан мэдэгдэл ирүүлнэ. - Компанийн улсын бүртгэлийн гэрчилгээний хуулбар - Компанийн НӨАТ-ын гэрчилгээний хуулбар - Захирлын иргэний үнэмлэхний хуулбар - Тендерт оролцогч нь харилцагч бүх банкнаас хугацаа хэтэрсэн өр төлбөргүй тухай лавлагаа эсхүл тододорхойлолт ирүүлнэ. Хэрвээ хугацаа хэтэрсэн өр төлбөртэй бол шаардлагад нийцээгүйд тооцно.
ТОӨЗ 3.1 - а	1. Хүнсний бүтээгдэхүүний чанар, аюулгүй байдлын шинжилгээний дүгнэлтийн эхээс хийсэн хуулбарыг нотариатаар гэрчлүүлэн ирүүлнэ, 2. Тухайн бараа материал худалдан борлуулах ажлын байр /дэлгүүр болон агуулах/-тай тогтмол үйл ажиллагаа явуулдаг байх ба нотлох баримтыг ирүүлнэ. Нотлох баримт гэж үйл ажиллагаа явуулж буй ажлын байрны зураг, байршил, түрээслэж буй бол түрээсийн гэрээ г.м байна.

ТОӨЗ 3.1 - б	1. Ижил төстэй ажил гэрээгээр гүйцэтгэсэн туршлагын мэдээлэл ирүүлэх жилийн тоо: 1 жил. 2019 он. Ижил төстэй бараа гэдэгт хүнсний бараа нийлүүлж байсан туршлагатай байх. Гэрээ ба гэрээ дүгнэх протокол /акт, дүгнэлт/-ыг нотариатаар гэрчлүүлсэн хуулбарыг тус бүр ирүүлснийг ойлгоно. 2. Борлуулалтын хэмжээ: 1 жил буюу 2019 он. /санал болгож буй үнийн дүнгээс багагүй байна/ 3. Ашигтай ажилласан байх жилийн тоо: 1 жил (2019 он)
ТОӨЗ 3.1 -в	1. Тухайн тендерт оролцогч хуулийн этгээд нь сүүлийн 3 жилийн хугацаанд худалдан авах ажиллагаа, гэрээний үүргийн гүйцэтгэлтэй холбоотой асуудлаар шүүхэд хариуцагчаар оролцож байсан эсэх талаарх лавлагааг Шүүхийн Ерөнхий зөвлөл, Шүүхийн төрөлжсөн архиваас тендер зарлагдсанаас хойш хугацаагаар авсан байна. Хэрэв хуулийн этгээд нь худалдан авах ажиллагаатай холбоотойгоор хариуцагчаар оролцож байсан бол анхан шатны түүх, давж заалдах шатны шүүх, хяналтын шатны шүүхийн шийдвэр, шүүгчийн захирамж зэргийг тус бүр ирүүлнэ. Мөн Шүүхийн шийдвэр гүйцэтгэх газраас иргэн, хуулийн этгээдэд өр төлбөртэй эсэх талаарх тодорхойлолтыг тендер зарлагдсанаас хойш хугацаагаар авсан байна. ***2.*** Тендерийн хэл нь: Монгол хэл дээр байна. Гадаад хэл дээрх баримт бичгийг заавал баталгаат орчуулгын хамт ирүүлнэ. ***3.*** Тендерт оролцогч нь тендерийн иж бүрдэл, баримт бичгийг бэлтгэн электрон хэлбэрт /Adobe PDF/ шилжүүлж, цахим хэлбэрээр ирүүлэх ба ирүүлсэн бүх материал тод, гаргацтай байх шаардлагатай бөгөөд уншигдахгүй материалыг ирүүлээгүйд тооцно
ТОӨЗ 4.1	Тендерт оролцогчийн санал болгосон үнэ нь төгрөгөөр илэрхийлэгдсэн байх ба гэрээг хэрэгжүүлэх хугацаанд тогтмол байх тухай мэдэгдэл ирүүлнэ. Үнийн тохируулгын нөхцөлтэйгээр ирсэн үнийн саналаас татгалзана.
ТОӨЗ 5.1	Тендерт оролцогчийн бэлтгэж ирүүлэх тендер нь дараах зүйлээс бүрдэнэ. Тендерт оролцогч, түүний нийлүүлэх бараа нь захиалагчийн шаардсан техникийн тодорхойлолт болон шаардлагад нийцэж буй эсэхийг нотлох баримтыг тусгайлан бэлтгэж тендерт ирүүлнэ. Нотлох баримт нь танилцуулга, зураг мөн өгөгдлийн хэлбэртэй байна.

Худалдан авах барааны талаарх дор дурдсан өгөгдлүүд нь тендерт оролцогчид өгөх зааварчилгаа/ТОӨЗ/-ны холбогдох зүйл, заалтын мэдээллийг гүйцээх, нэмэлт оруулах, эсхүл өөрчлөх зорилготой. Хэрэв ТОӨЗ-ны зүйл, заалттай зөрчилдвөл энэхүү хүснэгт дэх мэдээллийг зөв гэж үзнэ.

ТЕХНИКИЙН ТОДОРХОЙЛОЛТ

Барааны нэр: Лаазалсан мах

1. **Зорилго:** “Эрдэнэт үйлдвэр” ТӨҮГ-ын хэлтэс цех нэгжүүдийг эрүүл ахуйн стандарт, шаардлага хангасан чанартай бараа, бүтээгдэхүүнээр тасралтгүй хангахын тулд нийлүүлэгч аж ахуйн нэгжийг сонгон шалгаруулахад оршино.

2. **Барааны тодорхойлолт:** Бүтээгдэхүүн нь Монгол Улсын “Хүнсний тухай” хууль, “Хүнсний аюулгүй байдлыг хангах тухай” хуулийн заалтыг хангасан байх шаардлагатай бөгөөд хүний бие махбодын хэвийн үйл ажиллагаа, өсөлт хөгжилтийг дэмжих, үндсэн шимт бодис, эрдэс, амин дэмийн зохистой хэмжээ агуулагдсан байх. Монгол Улсын болон олон улсын шаардлага хангасан түүхий эд, бүтээгдэхүүн нийлүүлж, хүний эрүүл мэндийг дэмжин хамгаалах шаардлагатай хүнсийг үйлдвэрлэгч эсхүл албан ёсны гэрээт борлуулагч, итгэмжлэгдсэн төлөөлөгчөөр дамжуулан нийлүүлнэ. Хүнсний бүтээгдэхүүн нийлүүлэгч нь эрүүл ахуйн шаардлага хангасан чанартай бүтээгдэхүүн нийлүүлэх, дагалдах шинжилгээний бичгүүдийг нийлүүлэлт тухай бүрд тогтмол өгч байх шаардлагатай.

3. **Техникийн тодорхойлолт:** Мал, амьтны тураг мах, дотор эрхтэн, дайвар түүхий эдийг тухайн нэрийн бүтээгдэхүүн үйлдвэрлэх зааврын дагуу бэлтгэж, амт үнэр оруулагч бодис хүнсний нэмэлтийн хамт дангаар нь болон бусад ургамлын гаралтай түүхий эдийн хамт зориулалтын лааз болон бусад савлагааны материалд савлаж, дулааны боловсруулалт хийсэн бүтээгдэхүүн.

№	Бүтээгдэхүүний нэр	Барааны шинж чанар	Ангиллын төрөл	Стандарт	Физик химийн шинж чанар	Сав баглаа боодол
	Лаазалсан мах, элэгний нухаш	Лаазны битүүмжид ямар нэг гэмтэл согог үүсээгүй, гадаргуу нь цэвэр, цохигдсон зурагдсан шинж тэмдэггүй, дархад дуу гарахгүй, задлахад лаак нь ховхорч унаагүй, зэвэрч муудаагүй, Махан нөөш нь нэр төрөлдөө тохирсон бор хүрэн, ягаавтар улаан ба улаавтар хүрэн өнгөтэй, мах ногооны нөөш нь нэр төрөлд тохирсон өөрийн өвөрмөц өнгөтэй, нэр төрөлдөө тохирсон түүхий эдийн өвөрмөц амт үнэртэй, гадны амт үнэргүй	Үндсэн түүхий эдийн төрлөөр нь: - тураг махан/ үхэр, хонь, адуу, гахайн, цул, эсвэл ястай / - Дотор махан / хэл, элэг, зүрх гэх мэт - Мах ногооны - Нөөшилсөн бэлэн хоол / будаатай хуурга, бантан, ногоотой шөл гэх мэт - Нөөшилсөн дайвар / шөрмөс, годон гэх мэт / Түүхий эдийн боловсруулалтаар нь: - Жижиглэлтийн зэргээр / том жижиг, нухаш / - Давсны агууламжаар нь / давсалсан, давслаагүй / - Боловсруулалтаар нь чанасан, хуурсан - Бүрэлдэхүүн хэсгээр нь шөлтэй, шөлгүй Савлагааны төрлөөр нь: - Вакум битүүмжтэй - Ердийн битүүмжтэй Ариутгалын горимоор нь - Пастеризацийн /98-100^{0}C/ - аСтерилизацийн /108-а130^{0}C/	MNS 1563:2007	Боловсруулсан арга технологиос шалтгаалан хэт чанагдаагүй, нягтрал сайтай, шөл нь булингартай эсвэл цэлцгэнэсэн байдалтай, нэр төрөлдөө тохирсон жигд хэрчилттэй	Лаазалсан болон бусад төрлийн савлагаатай байна.

- Зохих байгууллагаас бараанд гарал үүслийн гэрчилгээг, шинжилгээний бичгийг нийлүүлэлт тухай бүр нь захиалагчид ирүүлэх.

- Нийлүүлэх бараа бүтээгдэхүүн нь дээр нэр дурдагдсан болон нэр дурдагдаагүй ижил төрлийн бараа бүтээгдэхүүнийг захиалагчийн тавигдсан шаардлага тоо хэмжээ нэр төрлийг хангаж байх.

- "Савласан хүнсний бүтээгдэхүүний шошгод тавих ерөнхий шаардлага" MNS CAC 1:2007 стандартын шаардлагыг хангасан дараах агуулга бүхий хаяг, шошготой байна. Үүнд:

• барааны тэмдэг ба үйлдвэрлэгчийн нэр хаяг;
• бүтээгдэхүүний нэр, ангилал;
• бүтээгдэхүүний цэвэр жин;
• үйлдвэрлэсэн он, сар, өдөр;
• найрлага, илчлэг чанар;
• хадгалах хугацаа;
• хадгалах нөхцөл;
• стандартын дугаар, тэмдэглэгээ.
• шошгын ерөнхий мэдээлэл монгол хэл дээр орчуулагдсан байна

- Шаардлага хангахгүй бүтээгдэхүүнийг эргүүлэн татан авалтыг гомдол чирэгдэлгүй хүлээн авч байх.

3. Шалгаж хүлээн авах

3.1 Бүх төрлийн лаазаласан махны техникийн тодорхойлолтын стандартын үзүүлэлт, шаардлага болон техникийн тодорхойлолтыг бүрэн хангасан байна.

3.2 "Эрдэнэт үйлдвэр" ТӨҮГ –т нийлүүлэх хүнсний бараа нь энэ стандартад заасан үзүүлэлтүүдийг итгэмжлэгдсэн хөндлөнгийн сорилтын лабораториор шинжлүүлж, дүгнэлт гаргуулсан байна.

3. 3 Нийлүүлж буй бараа бүтээгдэхүүний хадгалах хугацаа хамгийн багадаа 3-4 сар байх бүтээгдэхүүнийг хүлээж авна.

4. Савлах, хаяглах, хадгалах, тээвэрлэх

4.1 Нийлүүлэгч нь хүнсний барааг агааржуулалттай өрөөнд, хананаас 0,5 м-ээс багагүй зайд, шалнаас 10-аас 15 см өндөрлөсөн тавиур дээр хадгална.

4.2 Хүнсний бүтээгдэхүүнийг тээвэрлэхдээ ус чийг, шороо, тоосноос хамгаалагдсан зориулалтын тээврийн хэрэглэлээр тээвэрлэнэ.

5. Бараа хүргэх газар: "Эрдэнэт үйлдвэр" ТӨҮГ-ын нийтийн хоол, рестораны агуулахад хүлээлгэн өгнө.

БАРААНЫ ЖАГСААЛТ БА БАРАА НИЙЛҮҮЛЭЛТИЙН ХУВААРЬ

№	Нэр	Тоо ширхэг	Хэмжих нэгж	ТШӨХ-д заасан барааг хүргэх эцсийн цэг	Инкотермийн нөхцөлийн дагуу тогтоосон бараа нийлүүлэх хугацаа		
					Нийлүүлэх хамгийн эхний хугацаа	Нийлүүлэх эцсийн хугацаа	Нийлүүлэгчийн санал болгосон хугацаа
	1	2	3	4	5	6	7
1	Элэгний нухаш 190гр лаазтай	54	Ш	*DDP “Эрдэнэт үйлдвэр” ТӨҮГ-ын агуулах*	*Гэрээ байгуулснаас хойш хуанлийн 3 хоног*	*Гэрээ байгуулснаас хойш хуанлийн 30 хоног*	
2	Жигнэсэн мах 440гр Хүн –Од /дүйцхүйц/	1300	Ш	*DDP “Эрдэнэт үйлдвэр” ТӨҮГ-ын агуулах*	*Гэрээ байгуулснаас хойш хуанлийн 3 хоног*	*Гэрээ байгуулснаас хойш хуанлийн 30 хоног*	
3	Элэгний нухаш 100гр	450	Ш	*DDP “Эрдэнэт үйлдвэр” ТӨҮГ-ын агуулах*	*Гэрээ байгуулснаас хойш хуанлийн 3 хоног*	*Гэрээ байгуулснаас хойш хуанлийн 30 хоног*	
4	Элэгний нухаш /кг/	50	КГ	*DDP “Эрдэнэт үйлдвэр” ТӨҮГ-ын агуулах*	*Гэрээ байгуулснаас хойш хуанлийн 3 хоног*	*Гэрээ байгуулснаас хойш хуанлийн 30 хоног*	

Дөрөв. ЖИШИГ МАЯГТ

1. ҮНИЙН САНАЛЫН МАЯГТ

[огноо]

(Захиалагч байгууллагын нэр)-ын дарга _____ танаа

1. Бид, *[тендерт оролцогчийн нэр]* дор дурдсан барааг *[санал болгож буй нийт үнийг тоогоор болон үсгээр]* төгрөгөөр үнийн саналын авах баримт бичгийн дагуу *[тоо]* хоногийн дотор нийлүүлэхээр санал болгож байна.

2. Нийлүүлэх бараа нь техникийн тодорхойлолтын шаардлагыг бүрэн хангасныг гэрчлэх баримтыг хавсаргав.

3. Бид гэрээний ерөнхий болон тусгай нөхцөлийг хүлээн зөвшөөрч байна гэдгийг үүгээр батламжилж байна.

Нэр төрөл	Тодорхойлолт	Барааны гарал үүслийн улс	Тоо ширхэг	Нэгж үнэ	Нийт дүн	НӨАТ болон бусад албан татвар	Бүгд дүн
1	2	3	4	5	6	7	8
Тендерийн нийт үнэ							

4. Бид тендерийг холбогдох журмын дагуу бусад тендерт оролцогчдод ил болгохыг үүгээр зөвшөөрч байна. Захиалагч бидний ирүүлсэн тендерийг нууцлах аливаа үүргээс бүрэн чөлөөлөгдөнө.

Баталгаат засварын хугацаа:

Санал болгож буй бусад нөхцөл:

Тендерт оролцогчийн нэр:

Эрх бүхий албан тушаалтны гарын үсэг, тамга:

Албан тушаал, нэр:

Хаяг:

2. НЭГДСЭН ХҮСНЭГТ: ӨМНӨ БОЛОН ОДОО ХЭРЭГЖИЖ БУЙ ГЭРЭЭ

Тендерт оролцогч хэрэгжүүлсэн болон одоо гүйцэтгэж буй бүх гэрээний талаар мэдээлэл ирүүлнэ.

Уг мэдээлэл нь гэрээ хэрэгжүүлэх чадавхигүй болсон эсхүл ажил дуусгавар болсон гэрчилгээ буюу ажил хүлээлцсэн актаа хүлээн авч байгаа гэрээний хувьд хамаарахгүй.

Гэрээний нэр	Захиалагч, холбоо барих хаяг /утас/ факс	Гэрээний үнийн дүн	Гэрээний эхлэх хугацаа	Гэрээний дуусах хугацаа
1.				
2.				
3.				
4.				
5.				
бусад.				

Тав. ГЭРЭЭНИЙ ЕРӨНХИЙ НӨХЦӨЛ

1. Шалгах болон турших	1.1.	Техникийн тодорхойлолтыг хангаж буй эсэхийг баталгаажуулах зорилгоор захиалагч эсхүл түүний төлөөлөгч барааг шалгах, турших эрхтэй. Гэрээний тусгай нөхцөл (ГТН)-д, эсхүл техникийн тодорхойлолтод захиалагч ямар шалгалт, туршилтыг хэзээ, хаана хийхийг заана.
2. Барааны нийлүүлэлт ба баримт бичгийн бүрдүүлэлт	2.1.	Нийлүүлэгдэх бараа нь техникийн тодорхойлолтод нийцсэн байх ба холбогдох стандартыг заагаагүй бол тухайн барааны гарал үүслийн улсын зохих стандартад нийцсэн байна. Үүнд эдгээр стандартын хамгийн сүүлчийн найруулгыг ойлгоно. Нийлүүлэгч ГТН-д заасан бол түүний дагуу тээврийн болон бусад баримт бичгийг бэлтгэж бүрдүүлнэ.
3. Оюуны өмчийн эрх	3.1.	Бараа, эсхүл түүний эд ангийг өмчлөх, ашиглахад патент, худалдааны тэмдэг, зураг төслийн эрх гэх мэт оюуны өмчийн эрхийг захиалагч болон нийлүүлэгч зөрчсөн хэмээн гуравдагч этгээдийн нэхэмжилсэн гомдлыг нийлүүлэгч барагдуулж, холбогдон гарах зардлыг хариуцна.
4. Бараа хүргэх, тээврийн баримт бичиг ирүүлэх	4.1.	Гэрээнд хэрэглэсэн үнэ болон бусад худалдааны нэр томьёог Инкотермс (INCOTERMS) буюу Парис хот дахь Олон улсын худалдааны танхимаас боловсруулж гаргасан сүүлийн хувилбарт тодорхойлсон утгаар ойлгоно.
5. Баталгаат засварын хугацаа	5.1.	Үйлдвэрлэгчийн тухайн барааанд олгодог баталгаат засварын хугацаа *[тоо]* жил байна.
6. Гэрээнд өөрчлөлт оруулах	6.1.	Гэрээний дагуу нийлүүлэгдэх барааны нэр төрөл, үзүүлэлтийг өөрчлөхгүй.
7. Төлбөр	7.1.	Захиалагч төлбөрийг нэхэмжлэх хүлээн авснаас хойш *[ГТН-д заасан тоо]* хоногийн дотор шуурхай хийнэ.
8. Бараа нийлүүлэх хуваарь	8.1.	Нийлүүлэгч барааг хүргэхдээ техникийн тодорхойлолтод заасан бараа нийлүүлэлтийн хуваарийг мөрдөнө.

9. Алданги оногдуулах	9.1.	Захиалагч нийлүүлэгчийн хугацаа хоцорч нийлүүлсэн бараа, гүйцэтгэсэн үйлчилгээний гэрээний үнийн ГТН-д заасан хувьтай тэнцэх алданги оногдуулж, гэрээний үнийг тэр хэмжээгээр бууруулна. Алдангийн нийт дүн ГТН-д заасан дээд хэмжээнээс хэтрэхгүй.
10. Үүргээ биелүүлээгүй-гээс гэрээг цуцлах	10.1.	Нийлүүлэгч гэрээний үүргээ биелүүлээгүй тохиолдолд захиалагч гэрээг цуцалж, захиалагчид учирсан аливаа хохирлыг нийлүүлэгч барагдуулна.
11. Маргааныг шийдвэрлэх	11.1.	Талууд гэрээний үүргийн биелэлттэй холбогдсон асуудлаар тохиролцоонд хүрч чадахгүй бол зохих тал шүүхэд нэхэмжлэл гаргана.

Зургаа. ГЭРЭЭНИЙ ТУСГАЙ НӨХЦӨЛ

1. Шалгах болон турших (ГЕН – 1)	1.1.	[Гэрээний ерөнхий нөхцөлийн 1 дүгээр зүйлийг дэлгэрүүлэх шаардлагатай бол ямар шалгалт болон туршилтыг хэн, хэзээ хийх нөхцөлийг заана.]
2. Барааны нийлүүлэлт ба баримт бичгийн бүрдүүлэлт (ГЕН – 2)	2.1.	Нийлүүлэгчийн бүрдүүлэх тээврийн болон бусад баримт бичгүүд: 1) нийлүүлэгчийн барааны нэр, тоо ширхэг, нэгж болон нийт үнийг заасан нэхэмжлэхийн хувь; 2) барааг хүргэсэн тухай баримт, төмөр замын болон тээврийн баримт; 3) үйлдвэрлэгчийн буюу нийлүүлэгчийн баталгаат засварын гэрчилгээ; 4) үйлдвэрийн буюу эрх бүхий байгууллагын шалгалтын гэрчилгээ; 5) барааны гарал үүслийн гэрчилгээ. Энд жагсаасан баримт бичгийг бараа хүрэлцэн ирэхээс өмнө захиалагчид өгсөн байна. Баримт бичгийг энэ хугацаанд захиалагчид өгч чадаагүйгээс гарах зардлыг нийлүүлэгч хариуцна.
3. Баталгаат засвар (ГЕН-5)	5.1.	Баталгаат засварын тусгай шаардлага. [Гэрээний ерөнхий нөхцөлийн 5 дугаар зүйл нь баталгаат засварын тухай нийтлэг заалтыг агуулна. Энэхүү нийтлэг заалтыг өөрчлөх шаардлага гарвал энд тусгана.]
4. Төлбөр (ГЕН – 7)	7.1.	Гэрээний ерөнхий нөхцөлийн 7 дугаар зүйлийг дараах байдлаар дэлгэрүүлнэ. Үүнд: Гэрээний үнийн дүнгийн *[тоо]*[1] хувийг барааг хүлээн авсан акт болон гэрээний ерөнхий нөхцөлийн 2 дугаар зүйлд заасан баримт бичгийг үндэслэн төлнө.

[1] Ихэнх тохиолдолд 100 хувь байна. Шаардлагатай бол төлбөрийн хуваарийг өөрчилнө.